



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 4/78

Улаанбаатар хот

┌ Зочид буудал, дэн буудал, амралтын ┐
газрын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох, хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1 дэх хэсэг, Газрын дүрмийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгосугай.

2. “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгосугай.

3. “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS 6043:2019” стандарт, “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын шаардлагыг хангасан хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 1 жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Баруун-Оргил ХХК-ийн “Бадрал” зочид буудлын 19/302, Зүүнбаян рейфайнери ХХК-ийн “Пийс бридж” зочид буудлын 19/365, МҮЭХ-ҮҮТөв-ийн “Альфа” зочид буудлын 19/341, Комо юнайтед инк ХХК-ийн “Гүүд дэй” зочид буудлын 19/367, Касио ХХК-ийн “Ану” дэн буудлын 19/358, Оршил


1150500250

гранд ХХК-ийн “Оршил резорт” амралтын газрын 19/406 тоот гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллагуудтай гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Р.Батням/-т үүрэг болгосугай.


6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн Удирдах газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон/-д үүрэг болгосугай.

7. Зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжүүдээс гэрчилгээний үнийн 5,000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.



С.БАТБААТАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 10 сарын
14-ний 1 өдрийн А/78 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт



ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 10 дугаарсарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Баруун Оргил ХХК	5432685	Бадрал	БГД-ийн 20-р хороо, Толгойт, 2-р цахилгаан станцын баруун талд
2	Зүүнбаян рефайнери ХХК	2637634	Пийс бридж	ХУД-ийн 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө, Дунд гол гудамж-47
3	Монголын үйлдвэрчний эвлэлийн холбооны харьяа үйлдвэрлэл үйлчилгээний төв	1067273	Альфа	СБД-ийн 1-р хороо, Нарны зам 64
4	Кома юнайтед инк ХХК	2772515	Гүүд дэй	БГД-ийн 8-р хороо, Жамсранжавын гудамж 14

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 10 сарын
14-ний өдрийн А/78 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

5284325 СБТ 8936 1118263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Тэрбилэг ХХК	5917751	Талст	ЧД-ийн 13-р хороо, Сургуулийн 1-1 тоот
2	Касио ХХК	2664402	Мөнх Оюу	СХД-ийн 27-р хороо, Толгойт 22

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2020 оны 10 сарын
14-ний өдрийн А/78 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ-8936 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2020 оны 10 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хүч эбле таун ХХК	5705908	Тэрэлж Алтай резорт	НД-ийн 1-р хороо, Горхи Тэрэлжийн БЦГ
2	Оршил гранд ХХК	5660955	Оршил резорт	БЗД-ийн 20-р хороо, Шар хоолойн ам
3	Дүнхэн уулын буурал улиастай ХХК	5884276	Ресорт ворлд Тэрэлж хотел	НД-ийн 6-р хороо, Антын ам173

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР